

МОНГОЛ ДАХЬ БРИТАНИ СУДЛАЛ

*Д.Золбоо**

Дэлхийн түүх, соёлын үнэт уурхайн нэг, өнөө үед олон улсын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлогч хүчирхэг гүрний нэг британи судлал манай оронд төдийлөн хөгжөөгүй боловч олон нийтийн дунд Британий талаарх мэдээлэл, мэдлэг тодорхой хэмжээнд байсаар ирсэн. Тиймээс ч британичуудын хүн төрөлхтний түүхэн хөгжилд оруулсан хувь нэмрээс дэлхийн бусад ард түмний нэгэн адил хүртэж, танилцаж ирсэн билээ.

Монгол туургатны мандан бадарч явсан Их Монгол Улсын үед Британид элч төлөөлөгч илгээж, харилцаж байсан тухай мэдээ байдаг боловч энэ талаар тодорхой тэмдэглэсэн түүхэн сурвалж одоогоор харахан олдоогүй байна. Манай архивуудад байгаа Британий талаар тэмдэглэн үлдээсэн анхны баримт нь 1912 оны Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны бичиг болон Монголд үйл ажиллагаа явуулж байсан Британий пүүсүүдийн холбогдолтой бичиг баримтууд ажээ.

Орон судлалын нэгэн томоохон салбар британи судлал манай оронд дорвитой хөгжөөгүй нь дараах учир шалтгаантай холбоотой гэж үзэж болно. Үүнд, 1920-иод оны дундуур БНМАУ-ын Засгийн газрын санаачилгаар Өрнөдийн улс гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн харилцаагаа хөгжүүлэх зорилтын хүрээнд цөөнгүй монгол залуусыг баруун Европын улс орнууд болох Герман, Францад явуулж сургасан. Эдгээр улсад суралцсан хүүхдүүд эх орондоо ирсний хойно тухайн орон судлалын эхийг анхлан өөрийн оронд тавьсан гэж үздэг. Харин тэр үед Британид оюутан, судлаач явуулаагүй явдлыг газар нутгийн хувьд хол, улс төр, үзэл суртлын үүднээс тухайн цаг үедээ Герман, Франц улстай харьцуулахад дэлхий дээрх хамгийн олон колони оронтой хүчирхэг гүрний нэг байсан болон Зөвлөлт Орос оронд Британий нөлөө Франц шиг их байгаагүйтэй нь холбож тайлбарлах нь бий. Иймээс манайд европын бусад орон судлалтай харьцуулахад британи судлал нэлээд хожим үүсэн бий болсон юм.

Манайд британи судлалын ажил төдийлөн хөгжөөгүйн хамгийн энгийн жишээ нь энэ орны нэрийг монгол хэлэнд олон янзаар нэрлэж хэвшсэнээс тодорхой харагддаг.

Тухайлбал ХХ зууны эхэн үеийн Монголын гадаад харилцааны түүхэнд холбогдох архивын бичиг баримт, тухайн үеийн төрийн албан хэрэг хөтлөлтөд болон эрдэмтэн, номын мэргэдийн бүтээл туурвилаас сөхөн үзвэл зарим нэр томъёо түүний дотор дэлхийн улс орнуудын

* Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

нэрсийг хятад хэлний дуудлагаар тэмдэглэн буулгасан байдаг. Тиймдээ ихэвчлэн хятад хэлэнд тэмдэглэдэг ханз болох “инг”, мөн зарим тохиолдолд англи хэлний “english” гэдгийн шууд дуудлага “инглиш” гэх зэргээр тэмдэглэсэн байх нь бий.

Харин өнгөрсөн зууны сүүлийн хагасаас эхлэн орос болон ернийн бусад хэлний нөлөөгөөр “англи улс” гэж нэрлэж дуудах болсон билээ. Энэ нэр томъёо нь уг улсын бүрэлдэхүүнд багтах дөрвөн улсын зөвхөн нэгийг нэрлэж, бусдыг нь төлөөлж чадахгүй байгаа тул ийнхүү нэрлэх нь зохимжгүй юм. Түүнчлэн зарим тохиолдолд Их Британи хэмээн нэрлэдэг нь мөн ташаа ойлголт болох ажээ. Учир нь Их Британи гэдэг нь Англи, Уэльс, Шотланд орших тэрхүү арлаа нэрлэдэг газар зүйн холбогдолтой нэр томъёогоор голлон хэрэглэгддэг байна.

Гэхдээ зарим тохиолдолд англиар “Anglo-Mongolian relationship”, “Anglo-Mongolian Society” гэх зэргээр хэлж, бичих тохиолдол буйг анхаарахгүй өнгөрч болохгүй байх. Энэ тохиолдолд ч гэсэн Британи гэж орчуулахад болох бөгөөд энэ нь англи хэл дээр “england”, “anglo” гэдэг 2 үгийг монгол хэлэнд “англи” гэж адилхан орчуулдагтай холбоотой. Зүй нь бид england гэдгийг анхнаас нь дуудлагаар нь тэмдэглэж занших хэрэгтэй байсан бололтой.

Иймд цаашид албан болон бусад хэвлэл мэдээллээр улсыг нь ерөнхийд нь төлөөлүүлэн нэрлэхдээ Британи гэж ярьж, бичиж заншвал зүйтэй болов уу. Мөн англи хэлэн дэх “United Kingdom” гэдгийг монгол хэлнээ “Нэгдсэн вант улс” гэж буулгаж, нэрлэж хэвшсэн нь ч гэсэн зарим нэг талаар утгын зөрчилтэй байдаг байна. Учир нь хаант улс болон вант улс гэдэг нь хоорондоо зэрэг дэвийн нэлээд ялгаатай төдийгүй “Вант улс”-ын төрийн тэргүүнийг хатан хаан буюу хаан гэж нэрлэдэг нь ч ташаа болох ажээ.

Дэлхий нийтийн жишгээс үзвэл англи судлал, шотланд судлал, уэльс судлал, ирланд судлал зэрэг нь тус бүрдээ өөр өөрийн онцлог судалгааны объект бүхий салбар судалгааны чиглэл болон хөгжсөн байдаг байна. Тиймээс манайд ч гэсэн ерөнхий нэр болох британи судлал гэдгээр хэвшиж тогтох зүйтэй байна.

Ер нь британи судлал гэдэг нь маш өргөн цар хүрээг хамарсан томоохон салбар шинжлэх ухаан юм. Үүний тод илрэл бол зөвхөн англи хэл гэхэд л өнөөдөр дэлхийн 1 тэрбум гаруй хүн хэрэглэдэг хамгийн түгээмэл хэл болсон байхад Британий түүх бол дэлхийн шинэ үеийн түүхийн нэг гол хэсэг болсон байх жишээтэй байна.

XX зууны эхэн үеэс монголчууд британийг мэддэг болсон төдийгүй энэ талаар архивт хадгалагдаж буй албан бичигт тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Шинэ үеийн Монгол Улсын анхдугаар үндсэн хууль боловсруулах комиссыг 1922 оны 5-р сарын 19-нд Монгол Улсын

Засгийн газрын шийдвэрээр Шүүх яамны сайд Н.Магсаржав хурц, эрдэмтэн Ж.Цэвээн, түшмэл Бат-Очир нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулж байсан билээ. Тус комисс цөөхөн хүнтэй байсан учир Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажил нэлээд удааширч байсан ажээ. Тиймээс тус комиссоос Засгийн газарт тусгай санал өргөн танилцуулсны дагуу мөн оны 9-р сарын 1-нд Намын Төв хороо, Засгийн газрын хамтарсан хурлаас тогтоол гаргаж тэдний ажилд нэлээд тодорхой заалт өгөхдөө "...Үндсэн хуулийг ардын эрхт хэмжээт цаазат Англи мэт улсын хуулиас товчлон авч эдүгээгийн явуулан буй засгийн байдалд нийлүүлэн зохиох" гэх зэргээр тодорхой удирдамж өгчээ. Уг комисс Британи, Норвеги, Япон, АНУ, Орос зэрэг 5 улсын үндсэн хууль ба үндсэн хуулийн чанартай актууд, тэдгээрийн холбогдолтой бичиг зохиолыг орчуулж, үлгэр загвар авч болохыг магадлан судалж байсан байх юм. Уг комиссын гишүүн Ж.Цэвээний боловсруулсан Үндсэн хуулийн анхны төсөл нь Богд хааныг амьд сэрүүн байх үед нь зохиосон учраас хаант засагтай улсын хуулиас жишээ авсан байж болох заалт цөөнгүй байдаг ажээ. Соёлт хүн төрөлхтний хууль цаазын эртний дурсгалуудын нэг нь Британид 1215 онд латин хэл дээр бичигдэн баталсан 900 гаруй жилийн түүхтэй Magna Carta буюу Их хаарт бичиг (Их гэрээ гэж орчуулах нь бас бий) байдаг байна. Өнөөдөр Үндэсний Төв номын сангийн гар бичмэлийн сан хөмрөгт уг Их Хаарт бичгийн тухайн үед хийсэн монгол орчуулга нь гар бичмэлээрээ хадгалагдаж байна.

Уг комиссын гишүүд чухам хаанаас, ямар эх сурвалжаас хэрхэн олж авсан болон хэн гэдэг хүн орчуулсан талаар тэмдэглэж үлдээгээгүй хэдий ч ХХ зууны эхний Монголчууд энэ талын мэдээлэлтэй байсан гэдэг нь туйлын сонирхолтой юм.

Мөн 1920-иод оны сүүлээр Монголын түүхэнд анхны гэж нэрлэж болохуйц "Англи-Монгол толь бичиг"-ийг түүхэнд "япон" хэмээх А.Данзан зохиож байсан нь өнөөдөр гар бичмэлээрээ хадгалагдаж байна.

Манай оронд анхлан 1956 онд тухайн үеийн Монгол улсын их сургуульд англи хэлийг заах болсон цагаас Британи судлалын эхлэлийг тавигдсан гэж үзэж болох юм. Өнгөрсөн онд 50 жилийн ойгоо тэмдэглэсэн энэхүү тэнхим нь зөвхөн англи хэл заахаас гадна англи хэлний түүх, Британий түүх, уран зохиол, эдийн засгийн газар зүй, соёлын талаар танилцуулах сургалт явуулж багагүй туршлага хуримтлуулжээ. Анхны оюутнуудад тухайн үеийн ЗХУ-ын багш мэргэжилтнүүд хичээл зааж байсан хэдий ч 1960-аад оноос ЮНЕСКО болон Гадаад яамны шугамаар Британиас багш нарыг урьж ирүүлж байсан бөгөөд уригдан ирж байсан багш нар нь өндөр түвшинд

бэлтгэгдсэн мэргэжлийн хүмүүс байсныг тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Мөн 1969 оноос эхлэн МУИС-ын Гадаад хэлний тэнхимийн дэргэд англи хэлний оройн курс байгуулагдсан бөгөөд өдгөө хүртэл манай улсын улс төр, нийгмийн олон нэрт зүтгэлтнүүд болон нийтдээ 5000 орчим төгсөгчдийг бэлтгэн гаргажээ.

Британий талын санаачилга, тусламж дэмжлэгийн үрээр 1969-1990 оны хооронд Лийдсийн Их сургуульд манай төр захиргааны байгууллагын нийт 94 хүн тус бүр 6 сарын хугацаатай англи хэлний мэргэжил дээшлүүлэх курст суралцаж байсан нь тухайн үеийн монголчуудыг Британи орны талаарх үнэн бодитой мэдээлэлтэй болоход тодорхой хэмжээнд хувь нэмэр оруулсан гэж үзэж болох юм. Тэдгээрийн дотор өнөөгийн Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр болон УИХ-ын гишүүн Р.Амаржаргал, Гадаад хэргийн сайд асан Н.Туяа нарын улс төрчид багтаж, амжилттай суралцан төгсч байсан байна.

Гэвч дэлхий дахинд ноёрхож байсан “Хүйтэн дайн”-ны нөлөөгөөр Британи болон өрнийн бусад орны талаарх мэдээлэл олж авах боломж маш бага, бараг хаалттай байсан учраас судалгаа шинжилгээний ажил хөгжих нөхцөл хараахан бүрэлдээгүй. Тиймээс дэлхийн хэмжээний алдарт зохиолчид болох У.Шекспир, Даниел Дэфо, Свифт, Чарльз Диккенс нарын сонгодог зохиол болон англи хэлээрх түүх, соёлын бүтээлүүдийг голчлон орос хэлээр дамжуулан авч эх хэлнээ хөрвүүлэн өөрийн уншигчдын хүртээл болгож иржээ. Харин 1970-аад оны эхнээс Э.Хэмингуэй, Т.Драйзер, Ф.Баум зэрэг олон алдартны зохиолыг англи хэлнээс шууд орчуулан хөрвүүлж байсан нь энэ чиглэлийн үндэсний боловсон хүчин бэлтгэгдэж гарах болсонтой холбоотой.

Монголын ШУА-ийн бүтцэд Дорно дахин судлалын хүрээлэн байгуулагдсан цагаас эхлэн орон судлалын салбар зохих ёсоор хөгжих эхлэл тавигдсан билээ. 1971 онд Лийдсийн Их сургуулийн Утга зохиолын хүндэт доктор болж Монголын эрдэмтэдээс барууны Их сургуулийн хүндтэй цол авсан анхны хүн болох ШУА-ийн Ерөнхийлөгч Б.Ширэндэв, Монголчуудаас анхлан Кембриджэд суралцагсдын нэг доктор Н.Дангаасүрэн, Дорно дахины судлалын хүрээлэнгийн захирал, доктор Н.Ишжамц зэрэг эрдэмтдийн зарим нэг бүтээл гарах болсон. Энэ үеийн судлаачдын судалгааны чиглэл нь Монгол, Британий харилцааны түүх, тухайн үеийн эдийн засаг, улс төрийн харилцааны талаарх ерөнхий асуудлыг хөндөж байлаа.

Британи судлалд холбогдох анхны бүтээлүүдэд ИБУИНВУ-д ажиллаж, амьдарч байсан анхны элчин сайд Д.Балжинням “Миний үе, миний үг” (УБ.2002) дурсамж ном, болон элчин сайд С.Дамбадаржаа “Британий арал дээр Монгол гал голомт ассан нь”

(УБ. 1999) зэрэг дурдатгал номыг нэрлэж байна. Түүхийн амьд гэрч болсон ахмад дипломатуудын дуртгал зохиол нь тухайн цаг үеийн түүхэн үйл явцыг хойч үедээ таниулан үлдээхээс гадна улс орны талаар үнэтэй мэдээллийг өгч байдаг билээ. Тухайлбал БНМАУ-аас ИБУИИВУ-д суурин суухаар томилогдсон анхны элчин сайдын хувьд С.Дамбадаржаа гуайн дээрх ном нь 1. Монгол, Английн харилцааны эхэн үе, 2. Миний мэдэх Англи гүрэн гэсэн хэсгээс бүрдэх ажээ. Тиймдээ ч хоёр орны харилцааны түүхээс гадна Британий улс төр, эдийн засаг, соёл нийгмийн байгууламж болон Лондон хот, Лондончуудын тухай гэх зэрэг олон сонирхолтой мэдээллийг багтааснаараа ихээхэн сонирхолтой бүтээл болжээ.

Хоёр орны харилцааны түүхийг тухайлан гаргасан бүтээлээр Монгол Улсын Гадаад хэргийн яамнаас эрхлэн тогтмол гаргадаг “Гадаад харилцаа” албан сэтгүүлийн 2003 оны 127 дугаар товхимолыг нэрлэж болно. Түүнчлэн ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргасан “Монгол ба Өрнөд Европ” (УБ.2004) хамтын бүтээл, “Монгол-Британий харилцаа” (УБ. 2005) нэгэн сэдэвт судалгааны зохиолууд болон “Олон Улс Судлал” сэтгүүлд “Монгол Британий харилцаанд холбогдох архивын баримтын тойм”, “Монгол, Британий харилцааны тоймоос” зэрэг судалгааны өгүүлэл нийтлэгдсэн билээ.

Судлаач Д.Золбоогийн “Монгол-Британий харилцаа” зохиол нь энэ сэдвээр өмнө нь манайд тухайлсан бүтээл гарч байгаагүйгээрээ анхдагч бөгөөд судалгааны ажлыг хийхдээ Монгол Улсын Үндэсний төв архив, МАХН-ын архив, Гадаад хэргийн яамны Гадаад хэргийн төв архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа түүхэн баримт бичгүүд, Британид ажиллаж, амьдарч байсан ахмад дипломатчид, элчин сайдуудын дурсамж, тэмдэглэл, өдөр тутмын сонин болон бусад хэвлэлийн материал, гааль, статистикийн баримт мэдээлэл, интернэт дэх эх сурвалжаас авсан мэдээ, мэдээллээс түлхүү ашиглажээ.

Судлаач хоёр орны харилцааны түүхийг бусад өрнөдийн орны харилцаанаас ялгагдах онцлог, нийтлэг талыг гаргахын зэрэгцээ ерөнхийд нь 3 үе болгон үечлэн хувааж авч үзсэн байна. Үүнд:

1-рт Дипломат харилцаа тогтоохоос өмнөх үеийн харилцаа буюу эрт үеэс 1963 он хүртэл үе

2-рт Хүйтэн дайны үе буюу 1963-1989 он хүртэл үе

3-рт Шинэчлэлийн үеийн харилцаа буюу 1990 оноос өнөөг хүртэлх үе болгон энэхүү 3 үед холбогдох харилцааны онцлогыг баримт сурвалж дээр тулгуурлан тус бүрд нь задлан бичсэн байна.

Агуулгын хувьд Монгол, Британий харилцааны эрт болон эхлэл үед 1990 он хүртэлх үеийг хамруулан голчлон архивын баримт материал дээр тулгуурлан гаргасан. Харин харилцааны өнөө үеийн

түүхийг 1. Худалдаа хөрөнгө оруулалт, 2. Соёл, боловсрол, шинжлэх ухааны харилцаа, 3. Британий тусламж, 4. Британи дахь Монгол судлал, 5. Британи дахь Монголчууд гэсэн хэсэгт хуваан тодорхой гаргажээ.

Мөн хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойд зориулан 2003 оны нэгдүгээр сард Британий Гадаад болон Хамтын нөхөрлөлийн хэргийн яамнаас эрхлэн Лондон хотноо хэвлэсэн “Британи-Монголын харилцаанд холбогдох баримтын эмхтгэл 1962-1964, Британий архивын баримт бичгүүд” гэсэн баримт бичгийн эмхтгэл нь шинэ үеийн хоёр талын харилцааны түүхэнд холбогдох дорвитой бүтээл юм. Энэхүү эмхтгэлд тухайн үед тус улсаас Монгол Улсад сууж байсан элчин сайд П.Т.Рауз өмнөх үг бичин, Британий Гадаад болон Хамтын нөхөрлөлийн Хэргийн Яамны түүхч, судлаачид товч тайлбар хийжээ. Уг эмхтгэлд өмнө нь тэр бүр эрдэм шинжилгээний эргэлтэнд орж, нийтийн өмнө ил болгон гаргаж тавьж байгаагүй 49 баримтыг өнгөт гэрэл зургаар тавьсан байна.

Британи судлал тэр дундаа орон судлалын талаар нарийвчлан гаргасан дорвитой бүтээлийн тоонд төрийн захиргааны онол, удирдлага, харьцуулсан улс төр судлалын асуудлыг сонирхон судалдаг оюутан залуус, судлаачдад зориулан Удирдлагын академийн Нийгмийн удирдлагын тэнхмийн багш, докторант С.Зүлфикарын бичсэн “Британий төрийн тогтолцоо” (УБ. 2003) гэсэн ном юм. Уг бүтээл нь Британий төрийн тогтолцооны түүхэн хөгжлийг, түүний бүрдэл институтуудын эрх үүрэг, үйл ажиллагааны онцлог, өөрчлөлт, улс төрийн нам, сонгууль шүүх гэсэн дэд сэдвийн дагуу тайлбарлан, сүүлийн үеийн тоо баримт ашигласан чамбай бүтээл болсон ажээ.

1990 оноос Монгол оронд өрнөсөн өөрчлөлт шинэчлэлийн дараагаар манай нийгэмд гарсан нэг томоохон өөрчлөлт нь дэлхий дахинд болж буй даяаршлын нөлөөгөөр англи хэлний шаардлага, мэргэжилтэн боловсон хүчний хэрэгцээ, шаардлага эрчимтэйгээр нэмэгдэж ирлээ. Урьд өмнө голчлон орос хэл дээрх сурах бичгээр дамжуулан суралцдаг байсан бол өнөөдөр манай эрдэмтэн багш нарын боловсруулсан олон арван сурах бичиг, толь бичиг хэвлэгдэн гарчээ. Тухайлбал Д.Алтангэрэл “Англи Монгол толь” (30.000 гаруй үгтэй. УБ. 1996, 2002), Э.Чинбат “Англи Монгол толь” (100.000 гаруй үгтэй УБ. 1996. 2002) болон хамгийн сүүлд хэвлэгдэн гарсан “Оксфордын Англи Монгол толь” (УБ. 2006) зэргийг нэрлэж болох юм. Гадаад хэл сургалтын төвүүдээс гадна ерөнхий боловсролын сургуулийн заавал үзэх хичээлийн тоонд англи хэл орсон төдийгүй, манайд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн 100 гаруй их дээд сургуульд тодорхой хэмжээнд англи хэл зааж байна. Түүнчлэн англи

хэлний орчуулагч, багш зэрэг нарийн мэргэжлээр бакалавр, магистрт суралцаж буй зарим оюутнуудын хэл шинжлэлийн үүднээс англи хэлний харьцуулсан судалгаа хийсэн ажлууд цөөнгүй бий.

Сүүлийн 16 жилийн хугацаанд англи хэл болон Британи орныг сонирхох хүүхэд залуусын тоо хурдацтайгаар нэмэгдсэнээр британи судлал хөгжих боломж илүү нэмэгдсэн билээ. Тиймээс Монгол Улсад суугаа ИБУИНВУ-ын элчин сайдын яам болон Монголын төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэгтэйгээр олон нийтийн дунд “Англи хэлээр хэн сайн ярих вэ?”, “Британи орныг хэн сайн мэдэх вэ”, “Англи дуу дуулаачдын улсын уралдаан” зэрэг уралдаан тэмцээн тогтмол зохион байгуулагдаж ирлээ. Мөн өнгөрсөн 2005 оноос эхлэн Британид суралцаж, амьдарч байгаа монгол оюутан залуус оролцсон “Монгол орны хөгжилд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг Лондон хотноо зохион байгуулсан нь британи судлалд судалгаа шинжилгээний ахиц дэвшлийг авчрах нь гарцаагүй юм. Уг хуралд хэлэлцүүлэн эхний байр эзэлсэн илтгэлүүдийн эмхтгэл “Британи дахь Монголчууд - бидний эх орноо гэсэн сэтгэл” (УБ. 2005) номоос үзэж болно.

2000 оноос эхлэн Монгол Улсын Их Сургуулийн Гадаад хэл, соёлын сургуулийн Их Британи, Америк судлалын тэнхим англи хэлний багш, орчуулагчаас гадна орон судлалаар бэлтгэн британи судлалаар мэргэшүүлэн бэлтгэн төгсгөж байгаа нь энэ чиглэлийн боловсон хүчинтэй болох томоохон алхам болж байна.

Монгол, Британийн найрамдлын нийгэмлэг 1997 онд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. Монгол-Британийн найрамдлын нийгэмлэг нь хоёр орны нөхөрсөг харилцааны хөгжилд идэвхтэй туслалцаа үзүүлэх, хоёр орны иргэд болон байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих, санаа нэгт хүмүүсийн сайн дурын, нээлтэй, бие даасан, ашиг орлогын төлөө бус, нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага ажээ. Тус нийгэмлэгийн тэргүүлэгч, гишүүн байгууллага болон гишүүд нь ихэвчлэн Британид боловсрол эзэмшсэн, мэргэжил дээшлүүлсэн, Британиас Монгол Улсад элчин сайдаар сууж байсан хүмүүс, Британиас Монгол Улсад суугаа ЭСЯ-д ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа, мөн Британиас Монголд үйл ажиллагаа явуулж буй компани, аж ахуйн нэгжийн төлөөлөгчид, хувь хүмүүс байдаг.

Өнөөгийн дэлхийн улс төр, эдийн засаг, соёл иргэншил, даяаршлын эринд Британий гүйцэтгэж буй үүрэг, түүнтэй холбогдуулан ИБУИНВУ-ын Зүүн хойд болон Төв Азид чиглэсэн улс төр, эдийн засгийн бодлого, түүнд Монгол Улсын эзлэх байр суурь, Монгол орны гадаад харилцаанд тус оронтой харилцах харилцааны гүйцэтгэх үүрэг зэрэг олон чухал асуудал цаашид судалгаа шинжилгээний чухал талбар

болон хүлээгдэж, судлаачдын өмнө нээлттэй байгааг хэлэх нь зүйтэй юм. Өнөөдөр манай их дээд сургуулиудад англи хэлийг сонирхон судалж буй олон мянган оюутан залуус болон Британид суралцаж, амьдарч байгаа монголчууд ирээдүйд өөрийн оронд британи судлалыг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулах биз ээ.